



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, "Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын 2015 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 49 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган, олон улсын байгууллага, хандивлагч орон, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, шийдвэрлүүлж ажиллахыг Ойн бодлого, зохицуулалтын газар /М.Тунгалаг/, Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Д.ОЮУНХОРОЛ

Байгаль орчин, аялал-жуулчлалын сайдын
2017 оны 04 дүгээр сарын 21 ны өдрийн
1/38 дугаар тушаалын хавсралт



**ТӨРӨӨС ОЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДУНД
ХУГАЦАА (2017-2021 он)- НЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ	Бүтээгдэхүүн/үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг харуулах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Хэрэгжих хугацаа	Санхүүгийн Эх үүсвэр
1	2	3	4	5	6	7	8
<p>Зорилт 1. Ойг түймэр, өвчин, хортноос хамгаалах, хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох менежмент, чадавхийг бий болгон ойг хомсдол, доройтлоос сэргийлэх бодлогын хүрээнд:</p> <p>1.1. Түймрийн хор хөнөөлийн аюулыг сурталчлах ажлыг эрчимжүүлж, түймрийг зогсоох шороон зурвас, ойн халз зурвас гаргах зэрэг бусад ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн түймэртэй тэмцэх ажлын материаллаг баазыг бэхжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх</p>							
1.1.1	Ой, хээрт түймрийн аюулгүй байдлыг хангах, түймрээс учирсан хохирлыг тогтоох, тооцох дүрэм, журам, норм, нормативыг тогтмол шинэчлэн сайжруулах, тэдгээрт хяналт тавих тогтолцоог төгөлдөржүүлэх	Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах Евростандартыг нутагшуулж, мөрдүүлж эхэлсэн байна.	Батлагдсан стандарт байна.	БОАЖЯ	ОБЕГ МХЕГ ТАТМТ	2018 - 2021	УОНТХ
1.1.2	Ойн түймрээс сэргийлэх, түймэртэй тэмцэх ажлын материаллаг баазыг бэхжүүлж, Улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа болон сум дундын ойн ангид ой, хээрийн түймэр унтраах техник, тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах ажлыг санхүүжүүлэх	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах багаж, хэрэгслэ техник хангамж, чадавхи сайжирсан байна.	Түймрийн эрсдлийн бүсэд багтах ТХГЗ болон Ойн ангиудыг 3-4 төрлийн багаж, хэрэгслээр хангасан байна.	БОАЖЯ	УОК ОБЕГ ХХЕГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ
1.1.3	Ойн түймрээс сэргийлэх, түймэртэй тэмцэх талаар аймаг, нийслэл, сумын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг жил бүр дүгнэж, төлөвлөгөөт ажлыг санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд дутагдал гаргасан байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн орчин бүрдүүлэх	Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах орон нутгийн зөвлөл байгуулагдаж, орон нутагт хариуцлагын механизм бүрдэнэ.	Түймрийн эрсдэл бүхий 10 аймагт Засаг даргын захирамжаар орон нутгийн зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагаа тогтмолжсон байна.	БОАЖЯ	ОБЕГ МХЕГ ЦЕГ	2016 - 2021	-
<p>1.2. Улсын хил дамнасан түймрээс сэргийлэх, тэмцэх талаар хөрш орнуудтай хамтран ажиллах оновчтой тогтолцоо бий болгох</p>							

1.2. Улсын хил дамнасан түймрээс сэргийлэх, тэмцэх талаар хөрш орнуудтай хамтран ажиллах оновчтой тогтолцоо бий болгох

1.2.1	Улсын хилийн бүс, шаардлагатай газруудад түймрийн эсрэг шороон зурвас, зам, ойн зааг гаргах ажлыг зохион байгуулах зэргээр түймрийн тархалтаас сэргийлэх арга хэмжээг авах	Хил дамнасан түймрээс учирсан экологи, эдийн засгийн хохирлын хэмжээ багассан байна	Улсын хилийн дагуу 10-20 м –ийн өргөн 2000 км урт хүртэл түймрээс хамгаалах зурвас байгуулсан байна.	БОАЖЯ	ХХЕГ ОБЕГ Орон нутгийн БОАЖГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ
1.2.2	Хил дамнасан түймрээс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар хөрш орнуудтай Засгийн газар хооронд гэрээ байгуулах, байгуулсан гэрээг хэрэгжүүлэх, хил дамнан гарч байгаа түймрийн мэдээллийн сүлжээг сайжруулах	Дэлхийн түймрийн мониторингийн төвийн менежментийн нэгдсэн сүлжээнд хамрагдаж, гишүүн орон болсон байна.	Ой, хээрийг түймрээс хамгаалах талаар хөрш орнуудтай хамтран ажиллах хэлэлцээр байгуулсан байна.	БОАЖЯ	ОБЕГ ХХЕГ ТАТМТ	2017 - 2021	УОНТХ

1.3. Ойн түймрийн аюул бүхий үед эргүүл гаргах, түймрийг илрүүлэхэд сансрын мэдээлэл ашиглах, цахим харилцаа, үүрэн холбооны сүлжээ бий болгох ажлыг зохион байгуулан түймрийг шуурхай илрүүлж, унтраах

1.3.1	Ой бүхий аймаг, сумдад улирлын урамшуулалттай түймрийн эргүүлийг иргэд, ойн нөхөрлөлүүдтэй хамтран гаргах, түймэр унтраах сайн дурын бүлэг зохион байгуулах замаар түймрийг шуурхай илрүүлэх, урамшуулах үзүүлэх механизм бүрдүүлэх	Урамшууллын журам, заавар гаргаж мөрдүүсэн байна.	БОАЖ-ын Сайдын тушаалаар 1 журам батлуулж, мөрдүүлсэн байна.	БОАЖЯ	Хууль зүйн яам	2017 - 2021	УОНТХ ГДХХ
1.3.2	Зайнаас тандан судлах, агаарын болон газрын эргүүл гаргах замаар ойн түймрийг шуурхай илрүүлж, тэмцэх, арга хэмжээ авах	Ой, хээрийн түймрийн аюул болон түймрийн тархалтыг урьдчилан мэдээлэх мэдээллийн сүлжээтэй болно.	Ойн түймрийн мэдээллийн сантай болсон байна	БОАЖЯ	ОБЕГ ЦУОШГ ХХЕГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ

1.4. Ойн хөнөөлт шавжийн мониторингийн болон судалгааны талбай байгуулах, хөнөөлт шавжтай тэмцэх дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх

1.4.1	Ойн хөнөөлт шавжид шимэгч болон ангуулчилдаг зүйлийг илрүүлэх судалгаа хийх, тэдгээрийг лабораторийн нөхцөлд үржүүлэх	Лабораторийн нөхцөлд Ойд хөнөөл учруулдаг Сибирийн хүр, Өрөөсгөл хүр эрвээхэйг ангуулчилдаг шавжийн зүйл, тоог тогтоосон байна	Монгол орны нөхцөлд ангууч болон шимэгч шавжийг үржүүлэх техник-эдийн засгийн үндэслэл боловсрогдоно.	БОАЖЯ "ОСХТ" УТҮГ	Мэргэжлийн хүрээлэн	2017 - 2021	ШУТС
-------	---	--	---	-------------------------	---------------------	-------------------	------

1.4.2	Ойн хөнөөлт шавжтай биологи, биотехник, аргуудаар тэмцэх ажлын шинэ технологи турших ажлыг зохион байгуулах	Нанотехнологоор гаргасан бүслүүрийг/ шинэ технологи/ туршиж нэвтэрүүлсэн байна.	50-с доошгүй га ойн талбайд зохион байгуулна	БОАЖЯ "ОСХТ" УТҮГ	ОМБ, Мэргэжлийн хүрээлэн	2017 - 2021	УОНТХ
1.4.3	Ойн хөнөөлт шавжийн хэт олшролын хөдлөл зүйд ажиглалт судалгаа явуулах мониторингийн суурин цэгүүдийг байгуулах	Архангай, Булган, Завхан, Орхон, Сэлэнгэ, Төв, Хэнтий зэрэг аймгуудад ажиглалт судалгааны суурин цэгүүд байгуулагдсан байна.	Жилд 1-2 суурин цэг байгуулна.	БОАЖЯ "ОСХТ" УТҮГ	ОМБ, Мэргэжлийн хүрээлэн	2017 - 2021	УОНТХ
1.4.4	Ойн хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдээллийн санг үүсгэх цахим сүлжээ байгуулж, орон нутгийн мэргэжилтнүүдийг сургах	Улсын хэмжээний мэдээллийн сангийн цахим сүлжээ байгуулагдаж, орон нутагт мэргэжилтэн бэлтгэгдсэн байна.	Мэдээллийн санд 15 аймаг, нийслэл, 115 сумын сүүлийн 10 жилийн ойн хөнөөлт шавжийн тархалт голомт, тэмцлийн мэдээлэл оруулсан байна.	БОАЖЯ "ОСХТ" УТҮГ	ОМБ, Мэргэжлийн хүрээлэн	2017 - 2021	УОНТХ
1.5. Хөнөөлт шавжийн олшролын үед тэмцлийн арга хэмжээг хэрэгжүүлэх чадавх бий болгох							
1.5.1	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд дотоодын биобэлдмэлийн үйлдвэрүүдийг дэмжиж ажиллах	Дотооддоо үйлдвэрлэж байгаа 3 төрлийн биобэлдмэлийг хэрэглэж ойн хөнөөлт шавжны хөнөөлийн голомтыг хязгаарласан байна	Биобэлдмэлийг 50.0 мянган га хөнөөлийн голомттой ойн талбайд хэрэглэж, голомтыг арилгасан байна.	БОАЖЯ "ОСХТ" УТҮГ	ОМБ, Мэргэжлийн хүрээлэн	2017 - 2021	УОНТХ
1.5.2	Ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажлын чиглэлээр бусад орны туршлага судлах, хамтран ажиллах, боловсон хүчнийг сургах ажлыг зохион байгуулах	ОХУ, БНХАУ-ын эрдэм шинжилгээний байгууллага хооронд гэрээ байгуулсан байна.	Тус 2 улсад 2-5 мэргэжилтэн дадлагажуулсан байна.	БОАЖЯ "ОСХТ" УТҮГ	ОМБ, хүрээлэн	2017 - 2021	УОНТХ
Зорилт 2. Ойг нөхөн сэргээх, ойжуулах, тарьц, суулгац ургуулах, сор шилмэл модны сайн чанарын үр бэлтгэх хэмжээг нэмэгдүүлэн, арга технологийг сайжруулж, бодит хүчин чадлыг бий болгох замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:							
2.1.Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 2020 онд 8,3 хувьд, 2030 онд 9,0 хувьд тус тус хүргэх							
2.1.1	Ойжуулалтыг бүс нутаг бүрээр төвлөрүүлэн гүйцэтгэх, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг нэмэгдүүлэх замаар байгалийн аясаар сэргэн ургасан болон таримал ойг 2021 онд 310.0 мянган га-д хүргэх	Ойгоор бүрхэгдсэн талбай 310,0 мянган га талбайгаар нэмэгдсэн байна.	Байгалийн сэргэн ургалт болон ойжуулсан талбайд таримал модны амьдралт 80 хувиас багагүй байна.	БОАЖЯ	Аймаг, нийслэл БОАЖГ, Аж ахуйн нэгж, ойн нөхөрлөл	2017 - 2021	УОНТХ ААНБ ОМБХХ

2.1.2	Далд үндэсний систем бүхий тарьц бойжуулах арга, технологийг эзэмших замаар ойжуулалтын ажлын чанарыг сайжруулж, улирлын хамаарлыг багасгах	Ойжуулалтын ажлыг жилийн альч улиралд хийх арга, технологитой болно.	Бортого үйлдвэрлэх цех - 1 байгуулсан байна.	БОАЖЯ	"ОСХТ" УТҮГ, Мэргэжлийн хүрээлэн	2017 - 2021	ҮОНТХ ААНБ ОМБХХ
2.1.3	Ойг нөхөн сэргээх ажлын мужлал гаргаж, түүний дагуу байгаль цаг уурын бүс бүслүүр бүрт зохицсон ойжуулалтын ажлын технологи боловсруулах;	Байгалийн бүсийн ялгаагаар ойжуулалтын ажлын технологи, зөвлөмж гарна	Ойжуулалтын мужлалын дунд масштабын зураг - 1 зохиогдсон байна.	БОАЖЯ	Мэргэжлийн хүрээлэн	2017 - 2018	ҮОНТХ
2.1.4	Байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлын арга, технологийг сайжруулах;	сэргэн ургалтанд туслах ажлын арга, технологи шинэчлэгдсэн байна.	Байгалийн сэргэн ургалтын ойн талбайн хэмжээ 10-15 % -иар нэмэгдэнэ	БОАЖЯ	Мэргэжлийн хүрээлэн	2017 - 2018	ҮОНТХ
2.1.5	Заган ойг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх;	Заган ойн талбай 1000 га-гаар нэмэгдсэн байна	Байгалийн сэргэн ургалтанд туслах ажил гүйцэтгэсэн болон загжуулсан талбайд таримал загийн амьдралт 80 хувиас багагүй байна.	БОАЖЯ	Аймгуудын БОАЖГ, ОМБ-ууд	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ
2.1.6	Ойжуулалтын ажлын бүртгэл, мэдээллийн сан бий болгох, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;	Мэдээллийн санг бүрэн ажиллуулж, ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлын үр дүн сайжирч, хяналтын механизм бүрдсэн байна	Ойг нөхөн сэргээх ажлын мэдээллийн сан бий болсон байна	БОАЖЯ	Аймгуудын БОАЖГ, ОМБ-ууд	2017 - 2021	ҮОНТХ
2.2. Ойн үрийн аж ахуйн цогц бодлогыг хэрэгжүүлж, сор, шилмэл модны сайн чанарын үрээр ойг нөхөн сэргээх, үржүүлэх ажлын хэрэгцээг бүрэн хангах							
2.2.1	Ойн үрийн аж ахуйн эрх зүйн орчныг сайжруулж, үрийн аж ахуйн талаар баримтлах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	Модлог ургамлын үрийн тухай хууль батлагдсан байна.	Модлог ургамлын үрийн тухай хууль – 1.	БОАЖЯ	бусад байгууллагууд	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ
2.2.2	Монгол орны ойн үрийн мужлалыг нарийвчлан гаргах, ойн үрийн байнгын талбайн хэмжээг нэмэгдүүлэх	Газарзүйн ялгаатай нөхцлөөр Ойн үрийг тарих шинжлэх ухааны үндэслэл боловсруулсан байна.	Ойн үрийн мужлалын дунд масштабын зураг гарна. 250 га талбайд ойн үрийн байнгын талбай байгуулагдсан байна.	"ОСХТ" УТҮГ,	Ойн ангиуд, ЭШБ-ууд	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ

2.2.3	Ойн үрийн лаборатори болон ойн үрийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудын хүчин чадал, техник технологи, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх	Ойн үрийн магадлан итгэмжлэгдсэн лаборатори бий болно.	Магадлан итгэмжлэгдсэн Улсын ойн үрийн лаборатори - 1	БОАЖЯ	"ОСХТ" УТҮГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ
2.2.4	Генетик, селекцийн үндэстэй ойн үрийн плантаци байгуулах ажлын эхлэл тавих, шилмэл моддыг сонгон паспортжуулах	Ойн үрийн плантаци байгуулах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулна.	Шилмэл модны үрээр ургуулсан 10000 ширхэг тарьцтай болно.	БОАЖЯ	Мэргэжлийн хүрээ лэн	2017 - 2021	УОНТХ ГДХХ
2.5.5	Үрийн мэдээллийн сан байгуулах, хяналт, мониторингийн сүлжээг бий болгох	Үрийн аж ахуйн үйл ажиллагаа сайжирч, хяналтын механизм бүрдсэн байна.	Ойн үрийн мэдээллийн сан бий болно.	БОАЖЯ	Мэргэжлийн хүрээ лэн	2017 - 2021	УОНТХ ГДХХ

2.3. Тарьц, суулгац ургуулах дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлж, ойжуулалтын ажлын чанарыг сайжруулж, улирлын хамаарлыг багасгах

2.3.1	Байгаль цаг уурын эрс тэс нөхцөл, хуурайшилт, дулааралд дасан зохицсон мод, сөөгний тарьц, суулгац ургуулах	Стандартын шаардлага хангасан тарьц, суулгацтай болно.	Стандартын тарьц, суулгацын хэмжээ 2 дахин нэмэгдсэн байна.	БОАЖЯ	"ОСХТ" УТҮГ Ойн ангиуд, ЭШБ-ууд	2017 - 2021	УОНТХ ААНБ ОМБХХ
2.3.2	Далд үндэсний системтэй тарьц ургуулах технологи нэвтрүүлж, ойжуулалтанд хэрэглэх	Тарьц ургуулах бортогоны цех байгуулагдана.	Ойжуулалтын ажлын үр дүн 20 хувиар сайжирсан байна.	БОАЖЯ "ОСХТ" УТҮГ	"ОСХТ" УТҮГ Ойн ангиуд,	2017 - 2021	УОНТХ ААНБ ОМБХХ
2.3.	Бортогонд тарьц ургуулахад шаардлагатай хөрсний судалгаа явуулж, хөрс бэлтгэж, хэрэгцээг хангах нөхцлийг бий болгох	Бортогтой тарьц ургуулах хөрс бий болно.	Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээтэй, хөрсний нөөцтэй болсон байна.	БОАЖЯ "ОСХТ" УТҮГ	Ойн ангиуд, ЭШБ-ууд	2017 - 2021	УОНТХ ААНБ ОМБХХ

2.4. Монгол оронд агро-ойн аж ахуйн хөгжлийн үндэс суурийг тавих, хамгаалалтын ойн зурвас, ногоон байгууламж байгуулах

2.4.1	Жимс, жимсгэний аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих	Агро-ойн аж ахуйн үндэс суурь тавигдсан байна.	Жимс, жимсгэний аж ахуйнууд тогтвортой, ашигтай ажилладаг болсон байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ	2017 - 2021	УОНТХ ААНБ ОМБХХ
2.4.2	Бэлчээр, тариалангийн талбай, авто зам, төмөр	Улсын хэмжээнд	Ойн зурвас, ногоон	БОАЖЯ	БХБЯ,	2021	УОНТХ

	замын сүлжээг хамгаалах зориулалт бүхий ойн зурвас байгуулах ажлыг зураг төсөв, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх	байгуулах ойн зурвас, ногоон байгууламжийн зураг төсөв гарч, Ойн зурвас, ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байна.	байгууламжинд тарьсан мод, сөөгний амьдралт 95 хувиас багагүй байна		ЗТЯ, ХХААХҮЯ	он хүр тэл	ААНБ ОМБХХ
2.4.3	Говь, хээрийн хөрсийг хамгаалах, элсний нүүлтийг зогсоох зорилго бүхий "Ногоон хэрэм" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	Ойн зурвасын хэмжээ нэмэгдсэн байна. Хуурай, хэт хуурай нөхцөлд зохицон ургах тарьц, суулгацын нөөцтэй болно.	Говь хээрийн бүсийн МҮГ-үүд тогтмол үйл ажиллагаатай болж, ойн зурвасанд тарьсан модны амьдралт 85 хувиас багагүй байна.	БОАЖЯ	Ойн анги, ЭШБ-ууд	2021 он хүр тэл	УОНТХ
2.5. Бүтээмж сайтай, түргэн ургадаг модыг тарьж ургуулах замаар үйлдвэрлэлийн зориулалттай плантаци байгуулж, ойн тариалан эрхлэх үндэс суурийг тавих							
2.5.1	Үйлдвэрлэлийн зориулалттай модны болон эх ургамлын плантаци байгуулсан туршлагыг судалж, монгол оронд тохирох хэлбэр, байгуулах газрыг сонгох	Үйлдвэрлэлийн зориулалттай эх модны плантаци байгуулж, бүтээгдэхүүн гарсан байна.	Хангайн бүсэд 2 газарт плантаци байгуулах газар сонгогдож, зураг төсөв бэлэн болсон байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ Сум дундын ойн анги	2017 - 2021	УОНТХ ААНБ ОМБХХ
2.5.2	Сонгосон газарт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэн үйлдвэрлэлийн зориулалттай плантаци байгуулах эхлэл тавих	Үйлдвэрлэлийн зориулалттай модны чанар сайжирч, нэр төрөл олширсон байна.	Плантацийг 200 га-гаас багагүй талбайд байгуулна	БОАЖЯ ХХААХҮЯ СЯ	Салбар ын ТББ ААН	2021	УОНТХ ААНБ ОМБХХ
2.6. Экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор байгалийн гамшиг болон хууль бус мод бэлтгэл, уул уурхайн олборлолт, хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас устсан ойг нэн тэргүүнд нөхөн сэргээх							
2.6.1	Хууль бус мод бэлтгэл, уул уурхайн олборлолт, хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас устсан ойн талбайн хэмжээг гаргах, үнэлгээ хийх	Хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас устсан ойн талбайн хэмжээ гарч түүнийг ойжуулах зураг, төсөв, төлөвлөгөө бэлэн болсон байна.	Жилд 300 га талбайд төвлөрүүлэн ойжуулах замаар ойжуулалт хийсэн байна.	БОАЖЯ	Уул уурхайн ям, ЦЕГ, МХЕГ	2017 - 2020	УОНТХ ААНБ ОМБХХ
2.6.2	Хууль бус мод бэлтгэл, уул уурхайн олборлолт, хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас устсан ойн талбайн хохирлыг барагдуулах, зураг, төсөв, төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээх арга хэмжээ авах	Хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас устсан ойд төвлөрүүлэн ойжуулах замаар ойжуулна.		БОАЖЯ	Уул уурхайн ям, ЦЕГ, МХЕГ	2017 - 2021	УОНТХ ААНБ ОМБХХ

2.7. Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг үе шаттай бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх

2.7.1	Үндэсний REDD+-ийн (Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах) Стратеги боловсруулах	Монгол Улсын REDD+-ийн Үндэсний Стратеги боловсруулж, санхүүжилт тодорхойлсон байна.	Үндэсний REDD+-ийн стратегийн бичиг, баримт -1	БОАЖЯ	НҮБХХ, ХХААБ, Байгаль Орчны Хөтөлбөр	2017 - 2018	UN-REDD хөтөлбөр
2.7.2	Үндэсний ойн мониторингийн системийг бий болгох (Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил);	REDD+-ийн Үндэсний ойн мониторингийн системтэй болсон байна.	Бодлого, арга хэмжээнд мониторинг хийх арга зүй – 1 .	БОАЖЯ	НҮБХХ ХХААБ,	2017 - 2018	-
2.7.3	Ойн хүлэмжийн хийн суурь түвшин тогтоох (Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил)	Үндэсний эсвэл бүсийн түвшний Ойн хүлэмжийн хийн хяналтын түвшин батлагдсан байна.	12 сарын дараа үйл ажиллагааны төлөвлөгөө, 18 сарын дараа Үндэсний хэлэлцээр зөвшилцөлд хүрсэн байх	БОАЖЯ	НҮБХХ, ХХААБ, Байгаль Орчны хөтөлбөр	2017 - 2018	Монгол орны UN-REDD хөтөлбөр
2.7.4	REDD+-ийн Нийгэм, Байгаль орчны Сөрөг Нөлөөллөөс Урьдчилан Сэргийлэх Мэдээллийн системийн тогтолцоог боловсруулах (Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил)	REDD+-ийн Нийгэм, Байгаль орчны Сөрөг Нөлөөллөөс Урьдчилан Сэргийлэх зарчмын бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох	Хөтөлбөрийн нээлтээс хойш 20 сарын дотор сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны төслийг боловсруулж батлуулах	БОАЖЯ	НҮБХХ, ХХААБ, Байгаль Орчны Хөтөлбөр	2017 - 2018	Монгол орны UN-REDD хөтөлбөр

Зорилт 3. Ойн тогтвортой менежментийг бий болгон ойгоос гарах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, экологийн болон эдийн засаг, нийгмийн үр ашгийг сайжруулах зорилтын хүрээнд:

3.1. Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох

3.1.1	Ойн менежментийн төлөвлөгөөг улс, аймаг, нийслэл, тусгай хамгаалалттай газар, гэрээгээр эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлийн түвшинд шинэчлэн боловсруулж, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг тогтолцоонд шилжих	Ойд авч хэрэгжүүлэх шаардлагатай Ойн аж ахуйн арга хэмжээнүүд менежментийн төлөвлөгөөний дагуу тасралтгүй хэрэгжинэ.	Ойн менежментийн төлөвлөгөө: Улсын -1, аймаг, нийслэл - 22.	БОАЖЯ ХХААХҮЯ ОСХТ	Аймаг сумын ИТХ, ЗДТГ Ойн ангиуд ТББ-ууд	2017 - 2021	УОНТХ ААНБ ОМБХХ
-------	--	--	---	--------------------	--	-------------	------------------

3.1.2	Олон зорилтот үндэсний ойн тооллогын үр дүнд тулгуурлан эко-системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн нөөцийн хомсдол, доройтлыг зогсоох, ойг тогтвортой зүй зохистой ашиглах, нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Ойн тогтвортой менежментэд шилжинэ	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлж ойрхог чанарын үзүүлэлтийг 8.5 %-д хүргэнэ.	БОАЖЯ ХХААХҮЯ ОСХТ ТББ	ГОУХАН	2017 - 2021	УОНТХ ГДХХ
3.1.3	Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэх менежмент, арга зүйг сайжруулах	Ой тооллого, ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэх менежмент, арга зүй олон улсын жишигт ойртсон байна.	Аргачлал - 1, Аргазүйн стандарт - 1	БОАЖЯ ОСХТ	ГОУХАН	2017 - 2020	УОНТХ ГДХХ
3.1.4	Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх анхан шатны байгууллага-ойн ангийн мэргэжлийн болон техникийн чадавхийг сайжруулах, нэмэгдүүлэх	Ойн ангиудыг бэхжүүлж, чадавхжуулах замаар ойн аж ахуйн арга хэмжээг үр ашигтай явуулах шинэ тогтолцоог бий болно.	Сум дундын 38, сумын 5 ойн ангийг мэргэжлийн болон техник технологиор чадавхжуулсан байна.	БОАЖЯ Аймаг, сумын ЗДТГ	ОМБ- ууд	2017 - 2021	УОНТХ ГДХХ
3.2. Ойн биологийн олон янз байдлын хамгааллыг сайжруулах							
3.2.1	Биологийн олон янз байдал, экосистемийн онцгой ач холбогдол бүхий ойн сангийн газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч хадгалж, хамгаалах	Улсын тусгай хамгаалалттай газрын хэмжээ нэмэгдэж, биологийн төрөл зүйл хадгалагдана.	Улсын тусгай хамгаалалттай газар дахь ойн талбайн эзлэх хувь хэмжээг 35%-д хүрсэн байна.	БОАЖЯ	Аймаг сумын ИТХ, ЗДТГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ
3.2.2	Ойн экологи-эдийн засгийн үнэлгээний суурь үзүүлэлтийг бүтээгдэхүүний үнэ, өртөг, хэрэглээ, нийлүүлэлттэй уялдуулан шинэчлэх	Ойн эдийн засаг, нийгэм-экологийн үр өгөөжийг тооцсон экологи-эдийн засгийн багц үнэлгээ шинэчлэн тогтоогдож мөрдөгдөнө.	Сайдын тушаалаар Ойн экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн баталсан байна	БОАЖЯ	Аймаг сумын ИТХ, ЗДТГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ
3.3. Ашиглалтын ой бүхий нутагт ойн замын сүлжээг сэргээн өргөжүүлж, ойн нөөцийг иж бүрэн, зүй зохистой, тогтвортой ашиглах үйлдвэрлэлийг дэмжих							
3.3.1	а. Ойн төв зам байгуулахад гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оруулах ажил зохион байгуулах	Зам тавих салбар дундын механикжсан ААН байгуулагдаж ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.	Сэлэнгэ аймгийн Мандал суманд 30 км урт зам тавигдсан байна.	ХХААХҮЯ СЯ	Концес- соор	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ

3.3.2	Дотоодын мод боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэл боломжтой барилгын дотор хаалга, гал тогооны тавилга, сургууль цэцэрлэгийн ширээ сандал зэрэг зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын татварыг нэмэгдүүлж дотоод зах зээлийг хамгаалах	Импортлогч аж ахуйн нэгжүүдийн үндэсний үйлдвэрлэл эрхлэх сонирхол нэмэгдэж, дотоод зах зээл хамгаалагдсан байна.	Зарим нэр төрлийн барааны импортын татварыг 20% -иар нэмэгдүүлнэ	ХХААХҮЯ СЯ	БОАЖЯ, Салбарын ТББ	2017 - 2018	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.3.3	Төсвийн байгууллагуудын модон тавилгын хэрэгцээг дотоодын үйлдвэрүүдээс хангах эрх зүйн орчныг бүрдүүлэн хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар хийх (Зорилтот болон хязгаарлагдмал тендер, төрийн шууд худалдан авалт гэх мэт арга замаар);	Импортлоор худалдан авах бүтээгдэхүүний хэмжээ буурч, валютын урсгал дотооддоо хадгалагдна.	Стандартын шаардлага хангасан модон тавилга, ширээ, сандал үйлдвэрлэгднэ.	ХХААХҮЯ СЯ	БОАЖЯ, Салбарын ТББ	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.3.4	Хагас болон боловсруулсан модон бүтээгдэхүүний экспортын чиг хандлагыг шинэчлэх санал боловсруулах, наамал дүнг, цул модон хавтан, тавилга, технологийн цавчдас, шахмал хорголжин (pellets) түлш зэрэг мод, модон бүтээгдэхүүний экспортыг дэмжих	Ойн салбараас улсад орох эдийн засгийн үр ашиг дээшилсэн байна.	Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ нэмэгдсэн байна.	ХХААХҮЯ СЯ	БОАЖЯ, Салбарын ТББ	2017 - 2021	ГДХХ ААНБ ОМБХХ
3.3.5	Монгол гэрийн модны үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өөр материалаар орлуулан хийх, суурин болон нүүдлийн шинж байдалд тохирсон гэрийн шинэ загвар, хэрэглээний шинэ шийдлийг бий болгох, гэрийн үйлдвэрүүдийг хоршин ажиллах боломжийг бүрдүүлэх, гадаад зах зээлийн судалгаа хийж гэрийн экспортыг дэмжих	Монгол гэрийн брэнд үйлдвэрлэл хөгжиж, экспорт нэмэгдсэн байна.	Орчин үеийн хэрэглээнд нийцсэн шинэ стандарт батлагдсан байна.	ХХААХҮЯ	БОАЖЯ, Салбарын ТББ	2017 - 2021	ГДХХ ААНБ ОМБХХ
3.5. Ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн хатсан болон унанги мод, ойн бусад үлдэгдлийг боловсруулан, төрөл бүрийн модлог хавтан, шахмал болон био түлшний дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах							
3.5.1	"Ойн цэвэрлэгээ" Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хөтөлбөрийг санхүүжүүлэх арга хэмжээ авах	Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байх	Улсын болон орон нутгийн төсөвт тусгах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.	БОАЖЯ ХХААХҮЯ СЯ	Салбарын ТББ, ААН	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ

3.5.2	Ойн цэвэрлэгээгээр бэлтгэх хатсан мод, унанги, ойн бусад модлог үлдэгдлийн нөөцийн судалгааг үндэслэн түүнийг бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн байршил, хүчин чадлын тооцоог гаргах, бэлтгэсэн модон түүхий эдийг ангилж ялган боловсруулах технологийг сонгож нутагшуулан үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээг хангах	Цэвэрлэгээгээр бэлтгэж үйлдвэрлэлд хэрэглэх модны хэмжээ үнийг тогтоох, цэвэрлэгээнээс гарсан мод, модлог материалыг МДФ хавтангийн үйлдвэрлэлийн түүхий эд болгон нийлүүлэлтийг тодорхой болгох.	Цэвэрлэгээгээр бэлтгэсэн модны хэмжээ жил бүр нэмэгдсэн байна.	БОАЖЯ ХХААХҮЯ	Салбарын ТББ, ААН, ойн нөхөрлөл	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.5.3	Технологийн цавчдас бэлтгэх, шахмал хавтан /ДСП, MDF, WPC OSB/, төрөл бүрийн шахмал түлш, барилгын модон блок /арголит/-ийн үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх;	Дотоодын өртөг багатай чанар сайтай хавтангийн үйлдвэрийг хямд түүхий эдээр хангаж, эцсийн бүтээгдэхүүний үнэ бага, чанар өндөр байна.	ДСП үйлдвэр -1, WPC үйлдвэр - 2, шахмал, болон хорголжин түлшний үйлдвэр-10, модон блокны үйлдвэр-1 тус тус байгуулсан байна.	БОАЖЯ ХХААХҮЯ	Салбарын ТББ, ААН	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.5.4	Арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг орчин үеийн дэвшилтэд арга технологиор гүйцэтгэх замаар ойг доройтлоос хамгаалж, ойн санг эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах цэвэр ойг бий болгох	Ойн арчилгаа, цэвэрлэгээний ажилд шинэ арга, технологи нэвтэрүүлсэн байна.	Ойн арчилгаа, цэвэрлэгээний шинэ арга, технологийн дагуу жилд 2.0 мян/га доошгүй талбайд хийнэ.	БОАЖЯ	"ОСХТ" УТУГ, Аймгуудын БОАЖГ, Ойн анги, ОМБ, Ойн нөхөрлөл	Жил бүр	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.5.5	Ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан ойн сангийн судалгааг хийж, ойн цэвэрлэгээ хийх шаардлагатай талбай, нөөцийг тогтоох	Ойн доройтолд орсон ойн сангийн талбай, нөөц тодорхойлогдож, цэвэрлэгээний арга, технологи сонгогдсон байна.	Жилд 30.0 мянган га хүртэл талбайд судалгаа хийж, нөөцийг тогтоосон байна.	БОАЖЯ	"ОСХТ" УТУГ, Аймгуудын БОАЖГ, Ойн анги, ОМБ	Жил бүр	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.5.6	Хөрөнгө оруулалт, хөрөнгийн зээл болон бусад эх үүсвэрээс буцаан төлөгдөх нөхцөлтэйгөөр ойн арчилгаа, цэвэрлэгээний ажилд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж нутагшуулан, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх	Хөрөнгө оруулалт сайжирч, Жилд 20.0 мянга га талбайд Ойн цэвэрлэгээний ажил хийсэн байна.	Модны ашиглалтын түвшин 15-20%-иар нэмэгдсэн байна.	БОАЖЯ	"ОСХТ" УТУГ, Аймгуудын БОАЖГ, Ойн анги, ОМБ	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ

3.5.7	Ойн цэвэрлэгээний ажлын хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх иргэд, ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүд, жижиг аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлтөөр дэмжин орон нутагт ажлын байр бий болгох	Ойн мэргэжлийн байгууллага болон ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа чадавхижсан байна.	Жилд 15-аас доошгүй ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөл техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	БОАЖЯ ХХААХҮЯ	"ОСХТ" УТҮГ, Аймгууд ын БОАЖГ, Ойн анги, ОМБ, нөхөрлөл	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.6. Ойн нөөц бүхий аймаг, сумын иргэдийн ахуйн хэрэглээ, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар мод бэлтгэх журам гаргах							
3.6.1	Ойгоос мод бэлтгэх журмыг шинэчлэн боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангах	Байгаль орчинд халгүй технологиор ойн нөөцийг тогтвортой ашиглах мод бэлтгэлийн шинэ тогтолцоо бий болно	Нийтээр мөрдөгдөх захиргааны хэм, хэмжээ тогтоосон акт /журам/-1	БОАЖЯ	Салбарын ТББ ААН	2017	-
3.6.2	Ойн цэвэрлэгээний болон үндсэн ашиглалтын огтлолт, арчилгаа, цэвэрлэгээнд тавих ерөнхий шаардлага MNS-6447:2014 стандартыг шинэчлэх	Ойгоос мод бэлтгэх үйл ажиллагаа явуулахад экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах стандарт шаардлага тогтоогдоно	Аргазүйн стандарт-1	БОАЖЯ	"ОСХТ" УТҮГ ОМБ-ууд	2017 - 2018	-
3.6.3	Ойгоос мод бэлтгэх, талбай тусгаарлахад тавигдах ерөнхий шаардлага, аргазүйн стандарт боловсруулах	Ойгоос мод бэлтгэх, талбай тусгаарлах ажлын технологи, ажилбар стандартчлагдана.	Аргазүйн стандарт-1	БОАЖЯ	"ОСХТ" УТҮГ ОМБ-ууд	2017 - 2018	-
3.7. Олон улсын жишигт нийцсэн ойн мэргэжлийн байгууллагын итгэмжлэлийн үндэсний стандартыг бий болгож, 2020 он гэхэд ойн нөөцийг зөвхөн итгэмжлэл авсан аж ахуйн нэгж, байгууллага ашигладаг тогтолцоонд шилжих							
3.7.1	Ойн магадлан итгэмжлэлийн тогтолцоо, урамшууллын механизмыг бий болгох	Ойн мэргэжлийн байгууллагууд магадлан итгэмжлэгдсэн байна.	Магадлан итгэмжлэлийг бус байгууллага хийнэ	БОАЖЯ Салбар ын ТББ- ууд	Аймаг сумын ИТХ, ЗДТГ, ОМБ-ууд	2017 - 2020	ГДХХ ААНБ ОМБХХ
3.7.2	Магадлан итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн модон болон ойн дагалт бүтээгдэхүүнд магадлан итгэмжлэлийн лого ашиглах журам боловсруулж, зах зээлд нэвтрүүлэх	Магадлан итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд тусгай тэмдэг /лого/ -той зах зээлд борлогдоно.	Ойн тогтвортой менежментийн үр дүнд бий болсон мод, модон болон ойн дагалт бүтээгдэхүүнд тусгай лого тэмдэг ашигласан байна.	БОАЖЯ ХХАААҮЯ Салбар ын ТББ- ууд	Аймаг сумын ИТХ, ЗДТГ, Ойн ангиуд ОМБ-ууд	2017 - 2021	ГДХХ ААНБ ОМБХХ

3.7.3	Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Ойн магадлан итгэмжлэл явуулах журмын төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх замаар ойн магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчныг бий болгох	Ойн магадлан итгэмжлэл явуулах журмын төслийг боловсруулж, батлуулсан байна.	Магадлан итгэмжлэлийн эрх зүйн тогтвортой тодорхой орчин бий болно	БОАЖЯ ХХАААҮЯ ТББ-ууд	Аймаг сумын ИТХ, ЗДТГ, Ойн ангиуд ОМБ-ууд	2017 - 2018	-
3.7.4	Олон улсын жишигт нийцсэн ойн магадлан итгэмжлэлийн үндэсний стандартыг боловсруулж, нэврүүлэх	Олон улсын магадлан итгэмжлэлийг нэвтрүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.	Олон улсын шаардлагад нийцсэн байна.	БОАЖЯ ХХАААҮЯ ТББ-ууд	Аймаг сумын ИТХ, ЗДТГ, Ойн ангиуд ОМБ-ууд	2018 - 2020	ГДХХ ААНБ ОМБХХ
3.8. Сум, суурин газрын төсөвт байгууллагуудыг нэгдсэн халаалтад шилжүүлэх, мод орлох түлшний үйлдвэрлэлийг дэмжих, урамшуулах зэргээр түлшний модны хэрэглээг бууруулах							
3.8.1	Мод, модон материалын төрөлжсөн захын стандартыг боловсронгуй болгож, хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн үйлчилгээ явуулдаг горимд шилжүүлэх, ойн аж ахуйн бүтээгдэхүүний арилжааг эрхлэх төв биржийг байгуулах үндэслэлийг судалж боловсруулах	Мод модон бүтээгдэхүүний борлуулалт эрэлт хэрэгцээ нийлүүлэлт тодорхойлогдоно.	Стандарт батлагдсан байх, Үндэслэл боловсруулсан байх	БОАЖЯ ХХААХҮЯ	СХЗГ Салбар ын ТББ	2017 - 2018	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.8.2	Ойн цэвэрлэгээгээр бэлтгэх модны нөөцөд тулгуурлан төрөл бүрийн шахмал түлшний үйлдвэр байгуулан сум суурин газруудын төсөвт байгууллагуудыг нэгдсэн халаалтанд шилжүүлэх төсөл боловсруулан санхүүжилтийг олон улсын хөтөлбөрүүдэд хамруулах ажлыг зохион байгуулах	Хөрөнгө оруулалтын хэмжээ, үйлдвэрийн тоо нэмэгдсэн байна.	Шахмал түлшний борлуулалтыг 150 гаруй цэгт туршилтийн журмаар борлуулах.	БОАЖЯ ХХАААҮЯ	Салбар ын ТББ ААН	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.9. Ойн эрүүл орчин бүрдүүлж, хэвийн өсөлтийг ханган, ойн бүтээмжийг дээшлүүлэх							
3.9.1	Ой бүхий аймаг, сумдад улсын болон орон нутгийн төсвөөр ой анги байгуулах замаар ойн удирдлагын бүтцийг бэхжүүлж, хамтын эзэмшлийн ой нөхөрлөлийг мэргэжлийн удирдлагаар хангах, ойн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх	Орон нутагт Ойн анги-ойн мэргэжлийн байгууллага-ойн нөхөрлөл гэсэн гурвалсан бүтэц бүрдэж, ойн бодлогын зорилтыг хэрэгжүүлж, хяналт тавина.	Сум болон сум дундын ой нөхөрлөл тоо нэмэгдсэн байна	БОАЖЯ	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.9.2	Баруун, Төв, Зүүн болон Говийн бүсийг түшиглэсэн үлгэр жишээ Ойн аж ахуйг байгуулж, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг явуулах	Бүс нутгийн байгаль-нийгмийн ялгаагаар ойн аж ахуйг хөтлөх загвар бий болно.	Үлгэр жишээ 3 ойн анги бий болсон байна.	БОАЖЯ	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ	2017 - 2021	ҮОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ

3.9.3	Ойн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Ойн салбарын гадаад харилцаа өрөгжиж, олон улсын төсөл, хөтөлбөрүүд хэрэгжинэ.	Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудын Ойн форумын гишүүн орон болсон байна.	БОАЖЯ	Олон улсын байгууллага, хөтөлбөр төслүүд	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.10. Ойн нөхөрлөл өөрийн эзэмшлийн ойд менежментийн төлөвлөгөөний дагуу бие даасан үйл ажиллагаа явуулахад санхүүгийн болон техник, технологийн дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлэх							
3.10.1	Ой бүхий сумдад ойн нөхөрлөлүүдийг сайн дурын үндсэн дээр байгуулах, хамтын эзэмшлийн ойн аж ахуйг хөгжүүлэх	Ойг хамгаалах хамтын оролцооны шинэ менежментийг бий болгоно	Ойн нөхөрлөл, аж ахуй, нэгжид улсын ойн сангийн 20-с доогүй хувийг эзэмшүүлсэн байна.	БОАЖЯ	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ
3.10.2	Ойн нөхөрлөлүүдийн эдийн засгийн урамшууллын тогтолцоо, байгалийн нөөц ашигласны төлбөрийн хуваарилалт, дахин хуваарилалтын систем бий болгох	Ойн нөхөрлөлүүд бие даасан үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадавхитай болсон байна	Ойн нөхөрлөлүүдийн дундын сангийн орлого одоогийнхоос 2-3 дахин нэмэгдсэн байна.	БОАЖЯ	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ
3.10.3	Ойн салбарын хөтөлбөрүүд, менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлыг улс, орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө, дотоодын болон олон улсын хандив, тусламж, төслийн хөрөнгөөр тогтвортой санхүүжүүлэх	Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтууд хэрэгжиж, ойн салбарын гадаад харилцаа сайжирсан байна.	Ойн салбарт оруулах хөрөнгө оруулалт, санхүүгийн хэмжээ нэмэгдсэн байна.	БОАЖЯ	Төсөл, хөтөлбөр Аж ахуйн нэгж байгууллагууд.	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.11.Ойн дагалт баялгийн нөөцийг тогтоож, байгаль орчинд халгүй аргаар бэлтгэн ашиглах, судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэн, уламжлалт мэдлэгийг түгээн дэлгэрүүлж, нөөц, тархалт багатай ойн дагалт баялгийг байгаль дээр өсөж үржих, тэлэх боломжоор хангах, зориудаар тарималжуулах							
3.11.1	Нөөцийн судалгааг үндэслэн ойн дагалт баялаг болох зэрлэг жимс, самар мөөг, хүнсний болон эмийн ургамлыг бэлтгэх, хамгаалах, ашиглах нөөцийг бүсчилэн тогтоох	Ойн дагалт нөөц ашигласны төлбөрийн бүрдүүлэлт оновчтой болно.	Ойн дагалт нөөцийг хамгаалах, ашиглах Сайдын тушаал жил бүр гарсан байна.	БОАЖЯ ХХААХҮЯ	Салбарын ТББ, Аж ахуйн нэгж байгууллага	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ

3.9.3	Ойн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Ойн салбарын гадаад харилцаа өрөгжиж, олон улсын төсөл, хөтөлбөрүүд хэрэгжинэ.	Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудын Ойн форумын гишүүн орон болсон байна.	БОАЖЯ	Олон улсын байгууллага, хөтөлбөр төслүүд	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.10. Ойн нөхөрлөл өөрийн эзэмшлийн ойд менежментийн төлөвлөгөөний дагуу бие даасан үйл ажиллагаа явуулахад санхүүгийн болон техник, технологийн дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлэх							
3.10.1	Ой бүхий сумдад ойн нөхөрлөлүүдийг сайн дурын үндсэн дээр байгуулах, хамтын эзэмшлийн ойн аж ахуйг хөгжүүлэх	Ойг хамгаалах хамтын оролцооны шинэ менежментийг бий болгоно	Ойн нөхөрлөл, аж ахуй, нэгжид улсын ойн сангийн 20-с доогүй хувийг эзэмшүүлсэн байна.	БОАЖЯ	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ
3.10.2	Ойн нөхөрлөлүүдийн эдийн засгийн урамшууллын тогтолцоо, байгалийн нөөц ашигласны төлбөрийн хуваарилалт, дахин хуваарилалтын систем бий болгох	Ойн нөхөрлөлүүд бие даасан үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадавхитай болсон байна	Ойн нөхөрлөлүүдийн дундын сангийн орлого одоогийнхоос 2-3 дахин нэмэгдсэн байна.	БОАЖЯ	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ
3.10.3	Ойн салбарын хөтөлбөрүүд, менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлыг улс, орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө, дотоодын болон олон улсын хандив, тусламж, төслийн хөрөнгөөр тогтвортой санхүүжүүлэх	Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтууд хэрэгжиж, ойн салбарын гадаад харилцаа сайжирсан байна.	Ойн салбарт оруулах хөрөнгө оруулалт, санхүүгийн хэмжээ нэмэгдсэн байна.	БОАЖЯ	Төсөл, хөтөлбөр Аж ахуйн нэгж байгууллагууд.	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
3.11. Ойн дагалт баялгийн нөөцийг тогтоож, байгаль орчинд халгүй аргаар бэлтгэн ашиглах, судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэн, уламжлалт мэдлэгийг түгээн дэлгэрүүлж, нөөц, тархалт багатай ойн дагалт баялгийг байгаль дээр өсөж үржих, тэлэх боломжоор хангах, зориудаар тарималжуулах							
3.11.1	Нөөцийн судалгааг үндэслэн ойн дагалт баялаг болох зэрлэг жимс, самар мөөг, хүнсний болон эмийн ургамлыг бэлтгэх, хамгаалах, ашиглах нөөцийг бүсчилэн тогтоох	Ойн дагалт нөөц ашигласны төлбөрийн бүрдүүлэлт оновчтой болно.	Ойн дагалт нөөцийг хамгаалах, ашиглах Сайдын тушаал жил бүр гарсан байна.	БОАЖЯ ХХААХҮЯ	Салбарын ТББ, Аж ахуйн нэгж байгууллага	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ

Зорилт 4. Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

4.1. Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх санхүүгийн стратегийг үе шат бүрээр боловсруулж, хэрэгжилтийг хангах

4.1.	Ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг улс, аймаг, нийслэл, сум, хамгаалалттай газрын захиргаа, ойн анги, аж ахуйн нэгж байгууллага, ойн нөхөрлөлийн түвшинд жил бүр хэрэгжүүлж, тайлагнах, биелэлтийг дүгнэх	Улсад ойгоос орох орлогын татварын хэмжээ нэмэгдсэн байна.	Улсын ойн сангийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалт сайжирсан байна.	БОАЖЯ	Аймаг, нийслэл, сумын ЗДТГ, ойн анги, ТХГНЗ, ААН, нөхөрлөл	2017 - 2021	-
------	---	--	---	-------	--	-------------------	---

4.2. Ойг нөхөн сэргээх, ойжуулах, таримал ойг худалдан авах санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх

4.2.1	Ойг нөхөн сэргээх, ойжуулах, таримал ойг худалдан авах санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх, таримал ойг худалдан авах эрхзүйн орчинг сайжруулах	Улсын ойн санд нийлүүлэх таримал ойн хэмжээ нэмэгдэнэ.	Таримал ойг худалдан авах журам шинэчлэгдсэн байна.	БОАЖЯ	"ОСХТ" ТҮГ	2017 - 2021	Улсын төсөв
4.2.2	Нийслэл, аймгийн төв, суурин газрыг цэцэрлэгжүүлэх ажилд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Төв, суурин газрын ногоон байгууламж нэмэгдэнэ.	Санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна	БОАЖЯ	"ОСХТ" УТҮГ Аймаг, нийслэл, сумын ЗДТГ, аж ахуйн нэгж, нөхөрлөл	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ

4.3. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд хувийн болон аж ахуйн нэгж, байгууллагаас оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих хөшүүрэг, механизмыг бий болгох

4.3.1	Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд хувийн аж ахуйн нэгж, байгууллагаас хөрөнгө оруулалт хийхэд хөнгөлөлттэй зээл олгох механизм бүрдүүлэх	Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд хувийн аж ахуйн нэгж, байгууллагаас оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.	Хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудад зээл олгох эрх зүйн орчин бүрдсэн байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ СЯ, Мэргэжлийн байгууллага	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
4.3.2	Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийсэн хувийн аж ахуйн нэгж, байгууллагын нэмүү өртгийн ашиг орлогын татварт хөнгөлөлт үзүүлэх хууль эрх зүйн орчин бүрдүүлэх	Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд хувийн аж ахуйн нэгж, байгууллагаас оруулах хөрөнгө оруулалт эрчимжинэ.	Хамаарах хууль, эрх зүйн баримт бичгүүдэд өөрчлөлт орсон байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ СЯ	2017 - 2021	-

4.4. Ойн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цөлжсөн бүс нутгийг ойжуулах томоохон төслийг олон улсын байгууллага, бусад орны дэмжлэг, тусламжаар хэрэгжүүлэх

4.4.1	ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ болон АСЕАН, Европын холбооны улсууд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ХБОХөтөлбөр, ХХАБ, АХБ, ДДБХС, ДБС зэрэг олон улсын байгууллага, сантай ойн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх	Ой салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрийн тоо нэмэгдэж, мэргэжлийн боловсон хүчний чадавхи дээшилнэ.	Азийн улс орнуудын Ойн хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэн байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ БСШУСЯ, ойн ТББ- ууд	2017 - 2021	-
-------	---	---	--	-------	---------------------------------------	-------------------	---

Зорилт 5. Ойн эрхзүйн орчныг сайжруулан "ойн сайн засаглал"-ыг бий болгож, салбарын шинжлэх ухаан, сургалт, боловсрол, мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх зорилтын хүрээнд:

5.1. Салбар дундын зохицуулалт хийх чадавхи бүхий удирдлага зохион байгуулалтыг бий болгох

5.1.1	Төрийн өмчийн ойн санг ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэх замаар, тэднийг "менежментийн төлөвлөгөө"-ний дагуу үйл ажиллагаагаа бие даан явуулах эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх	Ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах салбар дундын зохицуулалт сайжирна.	Ойн сангийн 20,0-с доошгүй хувийг аж ахуй, нэгж байгууллагад эзэмшүүлсэн байна.	БОАЖЯ	"ОСХТ" УТҮГ Аймаг, нийслэл, сумын ЗДТГ, аж ахуйн нэгж, нөхөрлөл	2017 - 2021	ААНБ ОМБХХ
-------	--	---	---	-------	--	-------------------	---------------

5.2. Ойн мэргэжлийн байгуулагад ойн санг гэрээгээр эзэмшүүлэх, ой бүхий сумдад ойн нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлэх замаар ойн санг тодорхой эзэнтэй болгох

5.2.1	Ойн санг гэрээгээр эзэмшсэн аж ахуйн нэгж байгууллага, нөхөрлөлийн судалгаа гаргаж, дүн шинжилгээ хийж, цаашид авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, эрхзүйн орчинг сайжруулах	Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх үйл ажиллагааны бодлого, хандлага тодорхойлогдоно.	Мэдээллийн сантай болсон байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ, аймаг, нийслэл, сумын ЗДТГ, Ойн анги	2017 - 2018	-
5.2.2	Мод бэлтгэл, ойн нөхөн сэргээлт, хамгаалалтыг хослуулан ажиллах чадвар, техник технологи бүхий мэргэжлийн байгууллагад ойн санг гэрээгээр эзэмшүүлж, ойн нөөц, баялгийг ойн менежментийн төлөвлөгөөний дагуу ашиглуулах хууль эрхзүйн орчин бүрдүүлэх	Ойн санг эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын ажиллах эрх зүйн таатай орчин бүрдэнэ.	Мэргэжлийн байгууллагуудад магадлан итгэмжлэлийн сертификаци олгогдоно.	БОАЖЯ	ХХААХҮЯ, аймаг, нийслэл, сумын ЗДТГ, Ойн анги	2017 - 2021	-

5.2.3	Ой бүхий сумдын ойн нөхөрлөлүүдийн гэрээгээр эзэмших болон эзэмшиж байгаа ойн тооллого, зураг хийх, тажсагийн үзүүлэлт, менежментийн төлөвлөгөө гаргах ажилд мэргэжлийн болон санхүүгийн туслалцаа үзүүлж, ойн нөхөрлөл байгуулах, ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ажлыг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх	Ойн сан эзэнтэй болж, эзэмшсэн ойн нөөц, баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх санхүүгийн чадавхитай болж өрхийн орлого нэмэгдэнэ.	Тухайн ойн нөхөрлөлийн өрхийн орлогын 20-30 хувийг ойн ашгаас хүртэнэ.	БОАЖЯ	ОСХТ, ХХААХҮЯ, аймаг, нийслэл, сумын ЗДТГ, ойн анги	2017 - 2021	-
5.3. Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн дэргэд ойжуулалт, нөхөн сэргээлт, ой хамгаалал, мод ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи боловсруулах, нэвтрүүлэх, дамжуулах нэгж, инкубаторийн төв, өндөр технологийн жижиг, дунд үйлдвэр байгуулахыг төрөөс дэмжих							
5.3.1	Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн дунд дараах сэдвээр эрдэм шинжилгээний төсөл зарлаж хэрэгжүүлнэ. Үүнд: • Ойн экосистемийн төлөв байдал, өөрчлөлтийг тогтоох, ойн хомсдол, доройтлыг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, технологи боловсруулах • Ойжуулалт, ойг нөхөн сэргээх дэвшилтэт технологийг газар зүйн бүсээр ялгавартай боловсруулах. • Таримал ойг арчлах, хамгаалах, бүтээмжийг дээшлүүлэх технологийг боловсруулах ба мониторингийн системийг бий болгох • Ой өсөлт, бүтээмжийг нэмэгдүүлэх, ой ашиглалтын байгаль орчинд ээлтэй технологи боловсруулах.	<ul style="list-style-type: none"> 1-ээс доошгүй арга, технологи боловсруулагдсан байна. Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнд бий болсон таримал ойг арчлах, хамгаалах технологи, мониторингийн систем бүрдэнэ. Модны ногоон массын гарцын норм, норматив тогтсон байна. 	<ul style="list-style-type: none"> Ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах аргагүй, технологийн үндэслэл боловсруулж, үйлдвэрлэлд шилжүүлэх Таримал ойг арчлах, бүтээмжийг дээшлүүлэх арга технологи-1 Мониторинг судалгааны аргачлал-1 . норм, норматив-1 	БОАЖЯ	ХХААХҮЯ Эрдэм шинжилгээний байгууллага. Их, дээд сургууль	2017 - 2021	УОНТХ Бусад эх үүсвэр
5.3.2	Ойн салбарт дэвшилтэт технологи боловсруулах, нэвтрүүлэх, дамжуулах нэгж, инкубатор, инновацийн төв, өндөр технологийн жижиг, дунд үйлдвэр байгуулахад хөнгөлттэй зээл олгох орчин бүрдүүлэх;	Дэвшилтэт технологи боловсруулах, нэвтрүүлэх, нэгж, инкубатор, инновацийн төв, жижиг, дунд үйлдвэр байгуулагдсан байна.	Ойн салбарт дэвшилт технологи нэвтрүүлэх, дамжуулах нэгж, инкубатор, инновацийн чиглэлийн старт-ап компани байгуулах аргачлал боловсруулна.	БОАЖЯ	ХХААХҮ, СЯ, Эрдэм шинжилгээний байгууллага. Их, дээд ургууль	2017 - 2021	УОНТХ, Бусад эх үүсвэр
5.4. Ойн мэргэжлийн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын чадавхыг дээшлүүлэх ажилд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, улмаар ойн мэргэжилтэн, мэргэжлийн ажилтан, ажилчин бэлтгэх шаталсан сургалттай тогтолцоо бий болгох							
5.4.1	Их, дээд сургуульд ойн сургалт-эрдэм шинжилгээний лаборатори, сургалт-туршилтын полигон байгуулах, багаж, техник, тоног төхөөрөмжөөр хангах төслийг ээлж дараатай хэрэгжүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх	Ойн салбарын дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх материаллаг бааз бэхжинэ.	Их, дээд сургуулийн харъяанд ойн сургалт судалгааны төвүүд байгуулагдсан байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ БСШУСЯ	2017 - 2021	Төсөл, Хөтөл бөр, Бусад эх үүсвэр

5.4.2	Ойн мэргэжлийн ажилчин бэлтгэдэг үйлдвэр сургалтын төвүүдийг ойн сургалтын лаборатори, полигон байгуулах (бэхжүүлэх), багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангаж материаллаг баазыг бэхжүүлэх	Ойн мэргэжлийн бэлтгэдэг сургалтын материаллаг бэхжинэ, салбарын ажилчин үйлдвэр-сургалтын төвүүдийн бааз	Ой бүхий 4-6 аймагт мэргэжилтэй ажилтан бэлтгэх төвийг байгуулж, сургалтын хөтөлбөр батлагдсан байна.	БОАЖЯ	ХХААХҮЯ БСШУСЯ	2017 - 2021	УОНТХ, Бусад эх үүсвэр
5.5. Мод, модон материалын эрэлт нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээ авах, хууль зүйн хариуцлагыг чангатгах, иргэдийн оролцоог урамшуулах зэрэг арга механизмыг хэрэглэх замаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох							
5.5.1	Санкт-Петербургийн тунхагийг хэрэгжүүлж хууль бус мод бэлтгэхтэй тэмцэх арга хэлбэрийг боловсронгуй болгох замаар хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх	Хууль бус мод бэлтгэл, ашиглалттай холбоотой гэмт хэргийн тоог бууруулсан байна.	Хяналтыг камержуулж, агаараас бичиглэл хийх төхөөрөмж нэвтрүүлнэ.	БОАЖЯ	МХЕГ, ЦЕГ	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
5.5.2	Хууль бусаар мод бэлтгэсэн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэн, нөхөрлөл болон эрх бүхий албан тушаалтанд адийн засгийн хөшүүрэг, урамшуулал олгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх, сурталчилах, хэрэгжилтийг зохион байгуулах	Ойг хамгаалах иргэд, аж ахуйн нэгж байгууллагын идэвхи сайжирсан байна.	БОАЖЯ, Сангийн сайдын хамтарсан журам батлагдан гарсан байна.	БОАЖЯ	СЯ	2017 - 2019	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ
5.6. Олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, ойн экологийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулах талаар бүх нийтийг хамарсан ажил өрнүүлэх, ойн салбарын мэдээ, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх мэргэжлийн сэтгүүл, студи байгуулахыг төрөөс дэмжих.							
5.6.1	Боловсрол, соёл урлаг, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, ойн салбарын мэдээ, мэдээллийн сүлжээ бий болгож, экологийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулах, ойн бодлого, хууль тогтоомж, ойн талаархи мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд байнга хүргэж, ил тод байдлыг хангах	Ойн салбарын талаархи олон нийтийн мэдлэг сайжирч, төрөөс хэрэгжүүлж буй ажлын ил тод байдал хангагдана.	Улирал тутамд хэвлэгдэх мэргэжлийн сэтгүүл- 1	БОАЖЯ	ХХААХҮЯ	2017 - 2021	ГДХХ ААНБ ОМБХХ Бусад эх үүсвэр
5.6.2	Ойн салбарын тулгамдсан асуудал, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн ололт амжилт, тэргүүн туршлага, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах	Салбарын шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн ололт амжилтын талаар иргэд, олон нийт, гадаад, дотоодын түнш байгууллагын мэдлэг мэдээлэл сайжирсан байна.	Жил бүрийн 3-р сарын 21-ны өдрийг Үндэсний ойн өдөр болгож салбарын тулгамдсан асуудлыг хэлэлцдэг уламжлал тогтоно.	БОАЖЯ	ХХААХҮЯ	2017 - 2021	УОНТХ ГДХХ ААНБ ОМБХХ

ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛАЛ.

ЯАМД:

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХЯ	Батлан хамгаалахын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
СЯ	Сангийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Засгийн газрын агентлаг, бусад байгууллага:

СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
УОК	Улсын онцгой комисс
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦУОШГ	Цаг уур орчны шинжилгээний газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ТХГНЗ	Тусгай хамгаалалттай газрын нутгийн захиргаа
"ОСХТ" УТҮГ	"Ойн судалгаа, хөгжлийн төв" УТҮГ
ТАТМТ	Төв Азийн түймрийн менежментийн төв
ААН	Аж ахуйн нэгж

ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА:

АНЗД	Аймаг, нийслэлийн засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Тайлбар:

1. УОНТХ - Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
2. БНАТ- Байгалийн нөөц, ашигласны төлбөрийн тухай хуульд заасан орлогын зохих хувь хэмжээ;
3. ААНБ - Аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгө;
4. ОМБ - Ойн мэргэжлийн байгууллага
5. ОМБХХ – Ойн мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсийн хуримтлал;
6. ЭШБ – Эрдэм шинжилгээний байгууллага
7. ГДХХ - Гадаад орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс хэрэгжүүлэх төсөл, өгч буй тусламж, дэмжлэг, хандивын хөрөнгө;
8. ЖДҮХС - Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;
9. БСХБЗХ - Гадаад, дотоодын банк, сан хүүгийн байгууллагын зээлийн хөрөнгө;
10. ЯБС - Ядуурлыг бууруулах сан